



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Цэнхэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2026/80/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a> Архангай аймаг 2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Гроут финанс Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж Утас: 77721628 Цахим хаяг: Byambadorj@growthfinance.mn</p>
------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.24 № 59  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Т.МӨНХБАТ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цэнхэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх "Ерөнхий боловсрол" хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,147,164.1 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 3,086,083.6 мянган төгрөг зарцуулсан байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 үндсэн зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>498,262,444.56</b>	<b>235,285,067.34</b>
31	<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>345,162,505.78</b>	<b>79,733,043.76</b>
312	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>345,162,505.78</b>	<b>79,733,043.76</b>
3121	<b>Төгрөг</b>	<b>345,162,505.78</b>	<b>79,733,043.76</b>
31211	Төрийн сангийн харилцах	345,162,505.78	79,733,043.76
33	<b>АВЛАГА</b>	-	-
335	<b>Бусад авлага</b>	-	-
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>153,099,938.78</b>	<b>157,552,023.58</b>
351	<b>Түүхий эд материал</b>	<b>141,736,621.82</b>	<b>142,566,621.82</b>
35110	Тусгай зориулалттай материал	141,736,621.82	142,566,621.82
354	<b>Хангамжийн материал</b>	<b>11,363,316.96</b>	<b>14,985,401.76</b>
35410	Бичиг хэргийн материал	1,484,800.00	2,715,480.00
35420	Аж ахуйн материал	6,718,516.96	9,053,921.76
35450	Барилгын засварын материал	3,160,000.00	3,216,000.00
346	<b>Урьдчилж төлсөн зардал, тооцоо</b>	-	-
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,817,837,330.57</b>	<b>2,260,436,629.72</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,817,837,330.57</b>	<b>2,260,436,629.72</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,725,817,359.13</b>	<b>2,169,837,779.70</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,851,500,780.34	2,332,197,015.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	(469,423,868.04)	(523,358,295.39)
39203	Авто тээврийн хэрэгсэл	38,000,000.00	35,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(37,999,999.80)	(35,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	328,190,794.54	315,148,214.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(157,687,402.97)	(128,038,450.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	271,621,835.56	269,217,476.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	(104,344,638.19)	(103,732,516.72)
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,784,284.00	37,784,284.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(37,784,284.00)	(37,784,284.00)
39217	Ном	5,959,857.69	8,404,336.29
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>92,019,971.44</b>	<b>90,598,850.02</b>
39301	Програм хангамж	13,458,800.00	13,458,800.00
39302	Хасагдуулга	(1,894,828.56)	(3,315,949.98)
39303	Бусад биет бус хөрөнгө	80,456,000.00	80,456,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,316,099,775.13</b>	<b>2,497,721,697.06</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	-	<b>16,554,735.20</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>16,554,735.20</b>
413	<b>Өглөг</b>	-	<b>16,554,735.20</b>
41320	Байгууллагад өгөх өглөг	-	16,554,735.20
4136	<b>Бусад өглөг</b>	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,316,099,775.13</b>	<b>2,481,166,961.86</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,316,099,775.13</b>	<b>2,481,166,961.86</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	598,344,455.77	598,344,455.77

**Архангай аймгийн Цэнхэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

51100	Өмч: - төрийн	598,344,455.77	598,344,455.77
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,012,987,958.73</b>	<b>1,178,055,145.46</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,012,987,958.73	1,012,987,958.73
51220	Тайлант үеийн үр дүн	-	165,067,186.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	704,767,360.63	704,767,360.63
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,316,099,775.13</b>	<b>2,497,721,697.06</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,807,366,803.70</b>	<b>3,352,036,718.40</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>38,266,003.70</b>	<b>534,420,018.40</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>38,266,003.70</b>	<b>534,420,018.40</b>
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>6,269,500.00</b>	<b>4,089,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,269,500.00	3,984,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	105,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- үндсэн хөрөнгө	30,199,085.00	528,090,713.60
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	1,797,418.70	2,240,304.80
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,769,100,800.00</b>	<b>2,817,616,700.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,638,437,300.00</b>	<b>2,602,155,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,638,437,300.00	2,602,155,200.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>130,663,500.00</b>	<b>215,461,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	130,663,500.00	215,461,500.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	-	-
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>2,743,735,414.15</b>	<b>3,186,969,531.67</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,743,735,414.15</b>	<b>3,186,969,531.67</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,634,940,674.15</b>	<b>3,055,433,216.67</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,890,066,814.32</b>	<b>2,193,868,125.76</b>
210101	Цалин	1,199,513,543.50	1,272,511,218.44
210102	Нэмэгдэл цалин	603,965,706.82	809,937,318.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,950,000.00
210104	Урамшуулал	86,587,564.00	97,469,589.22
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>213,658,253.94</b>	<b>269,649,015.14</b>
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	145,232,260.65	183,918,931.04
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	17,168,971.89	21,988,829.76
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	8,702,730.45	11,170,154.57
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	8,510,937.73	10,538,259.89
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	34,043,353.22	42,032,839.88
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>109,704,886.00</b>	<b>225,432,227.20</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	12,587,297.00	18,415,992.00
210302	Түлш, халаалтын зардал	94,617,589.00	203,953,235.20
210303	Цэвэр, бохир усны зардал	2,500,000.00	3,063,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>45,181,175.90</b>	-
210408	Бараа материал акталсны зардал	45,181,175.90	-
2105	<b>Нормативт зардал</b>	<b>105,769,250.00</b>	<b>143,655,893.00</b>
210502	Хоол, хүнс	105,769,250.00	143,655,893.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,852,000.00</b>	<b>4,026,500.00</b>
210604	Урсгал засвар	5,852,000.00	4,026,500.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	-	-
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>26,897,288.43</b>	<b>39,188,191.12</b>

**Архангай аймгийн Цэнхэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,269,500.00	2,224,400.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	20,627,788.43	36,963,791.12
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>237,811,005.56</b>	<b>179,613,264.45</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,990,013.00	39,971,080.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	17,748,733.00	11,951,070.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	165,072,259.56	127,691,114.45
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>108,794,740.00</b>	<b>131,536,315.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>93,512,737.00</b>	<b>130,484,707.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	83,816,137.00	110,513,607.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,696,600.00	19,971,100.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>15,282,003.00</b>	<b>1,051,608.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,282,003.00	1,051,608.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>63,631,389.55</b>	<b>165,067,186.73</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>63,631,389.55</b>	<b>165,067,186.73</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	2,775,370,300.00	2,821,705,700.00
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	6,269,500.00	4,089,000.00
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	6,269,500.00	4,089,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,269,500.00	4,089,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,269,500.00	3,984,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	105,000.00
120009	Бусад орлого	-	-
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	2,769,100,800.00	2,817,616,700.00
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,638,437,300.00	2,602,155,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,638,437,300.00	2,602,155,200.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	130,663,500.00	215,461,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	130,663,500.00	215,461,500.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	2,527,773,606.69	3,044,935,462.02
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,527,773,606.69	3,044,935,462.02
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,426,651,368.69	2,913,435,147.02
2101	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,890,066,814.32	2,193,868,125.76
210101	Үндсэн цалин	1,199,513,543.50	1,272,511,218.44
210102	Нэмэгдэл	603,965,706.82	809,937,318.10
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	13,950,000.00
210104	Урамшуулал	86,587,564.00	97,469,589.22
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	213,658,253.94	269,649,015.14
210201	Тэтгэврийн даатгал	145,232,260.65	183,918,931.04
210202	Тэтгэмжийн даатгал	17,168,971.89	21,988,829.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,702,730.45	11,170,154.57
210204	Ажилгүйдлийн даатгал	8,510,937.73	10,538,259.89
210205	Эрүүл мэндийн даатгал	34,043,353.22	42,032,839.88
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	108,881,497.00	209,977,392.00
210301	Гэрэл, цахилгаан	12,587,297.00	18,515,892.00

**Архангай аймгийн Цэнхэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210302	Түлш, халаалт	93,794,200.00	188,398,500.00
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	3,063,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	-
2105	<b>Нормативт зардал</b>	105,013,580.00	143,692,393.00
210502	Хоол, хүнс	105,013,580.00	143,692,393.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,500,000.00	4,432,500.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	4,432,500.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	26,897,288.43	39,188,191.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,269,500.00	2,224,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,627,788.43	36,963,791.12
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	75,633,935.00	52,627,530.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,490,202.00	40,044,780.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,143,733.00	12,582,750.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	101,122,238.00	131,500,315.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	85,840,235.00	130,448,707.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	76,143,635.00	110,477,607.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,696,600.00	19,971,100.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	15,282,003.00	1,051,608.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,282,003.00	1,051,608.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг -Орон нутгийн төсөв	15,282,003.00	1,051,608.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b> (3)=(1)-(2)	247,596,693.31	(223,229,762.02)
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	58,667,100.00	42,199,700.00
	Дотоод эх үүсвэрээр	58,667,100.00	42,199,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	58,667,100.00	42,199,700.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	(58,667,100.00)	(42,199,700.00)
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	188,929,593.31	(265,429,462.02)
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	156,232,912.47	345,162,505.78
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	345,162,505.78	79,733,043.76

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
4-01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	598,344,455.77	704,767,360.63	949,356,569.18	2,252,468,385.58
4-02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	598,344,455.77	704,767,360.63	949,356,569.18	2,252,468,385.58
4-04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
4-05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
4-06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
4-07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
4-08	Тайлант үеийн үр дүн	-	-	63,631,389.55	63,631,389.55

**Архангай аймгийн Цэнхэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

4-01	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	598,344,455.77	704,767,360.63	1,012,987,958.73	2,316,099,775.13
4-02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	598,344,455.77	704,767,360.63	1,012,987,958.73	2,316,099,775.13
4-04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
4-05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
4-06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
4-07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
4-08	Тайлант үеийн үр дүн	-	-	165,067,186.73	165,067,186.73
4-01	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	598,344,455.77	704,767,360.63	1,178,055,145.46	2,481,166,961.86

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр )

Эдийн засгийн ангилал	Бүртгэлийн дансны код	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2	<b>3,209,208,700.00</b>	<b>3,086,083,554.02</b>	<b>123,125,145.98</b>	<b>96.16</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	21	<b>3,209,208,700.00</b>	<b>3,086,083,554.02</b>	<b>123,125,145.98</b>	<b>96.16</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	210	<b>3,070,712,900.00</b>	<b>2,955,634,847.02</b>	<b>115,078,052.98</b>	<b>96.25</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2101	<b>2,282,878,100.00</b>	<b>2,193,868,125.76</b>	<b>89,009,974.24</b>	<b>96.10</b>
Үндсэн цалин	210101	1,416,432,200.00	1,272,511,218.44	143,920,981.56	89.84
Нэмэгдэл	210102	809,599,700.00	809,937,318.10	(337,618.10)	100.04
Унаа хоолны хөнгөлөлт	210103	-	13,950,000.00	(13,950,000.00)	-
Урамшуулал	210104	56,846,200.00	97,469,589.22	(40,623,389.22)	171.46
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	2102	<b>285,752,300.00</b>	<b>269,649,015.14</b>	<b>16,103,284.86</b>	<b>94.36</b>
Тэтгэврийн даатгал	210201	194,311,500.00	183,918,931.04	10,392,568.96	94.65
Тэтгэмжийн даатгал	210202	22,860,200.00	21,988,829.76	871,370.24	96.19
ҮОМШӨ-ний даатгал	210203	11,430,100.00	11,170,154.57	259,945.43	97.73
Ажилгүйдлийн даатгал	210204	11,430,100.00	10,538,259.89	891,840.11	92.20
Эрүүл мэндийн даатгал	210205	45,720,400.00	42,032,839.88	3,687,560.12	91.93
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2103	<b>210,961,500.00</b>	<b>209,977,392.00</b>	<b>984,108.00</b>	<b>99.53</b>
Гэрэл, цахилгаан	210301	19,500,000.00	18,515,892.00	984,108.00	94.95
Түлш, халаалт	210302	188,401,500.00	188,398,500.00	3,000.00	100.00
Цэвэр, бохир ус	210303	3,060,000.00	3,063,000.00	(3,000.00)	100.10
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2104	-	-	-	-
<b>Нормативт зардал</b>	2105	<b>150,731,600.00</b>	<b>143,692,393.00</b>	<b>7,039,207.00</b>	<b>95.33</b>
Хоол, хүнс	210502	150,731,600.00	143,692,393.00	7,039,207.00	95.33
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2106	<b>4,500,000.00</b>	<b>4,432,500.00</b>	<b>67,500.00</b>	<b>98.50</b>
Урсгал засвар	210604	4,500,000.00	4,432,500.00	67,500.00	98.50
<b>Томилолт, зочны зардал</b>	2107	-	-	-	-
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2108	<b>40,085,600.00</b>	<b>39,188,191.12</b>	<b>897,408.88</b>	<b>97.76</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	210801	2,224,400.00	2,224,400.00	-	100.00

Архангай аймгийн Цэнхэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	210806	37,861,200.00	36,963,791.12	897,408.88	97.63	
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2109	<b>95,803,800.00</b>	<b>94,827,230.00</b>	<b>976,570.00</b>	<b>98.98</b>	
Бараа үйлчилгээний бусад зардал	210901	83,217,000.00	82,244,480.00	972,520.00	98.83	
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	210902	12,586,800.00	12,582,750.00	4,050.00	99.97	
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>138,495,800.00</b>	<b>130,448,707.00</b>	<b>8,047,093.00</b>	<b>94.19</b>	
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>			-	-	-	
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	213	<b>138,495,800.00</b>	<b>130,448,707.00</b>	<b>8,047,093.00</b>	<b>94.19</b>	
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	213205	118,524,700.00	110,477,607.00	8,047,093.00	93.21	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	213209	19,971,100.00	19,971,100.00	-	100.00	
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>3,209,208,700.00</b>	<b>2,820,654,092.00</b>	<b>390,314,208.00</b>	<b>87.89</b>	
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	131	<b>2,991,452,800.00</b>	<b>2,602,155,200.00</b>	<b>389,297,600.00</b>	<b>86.99</b>	
Улсын төсвөөс санхүүжих	131001	2,658,122,900.00	2,602,155,200.00	55,967,700.00	97.89	
Оны эхний үлдэгдлээс санхүүжих	131009	333,329,900.00	-	333,329,900.00	-	
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>		<b>215,461,500.00</b>	<b>214,409,892.00</b>	<b>1,051,608.00</b>	<b>99.51</b>	
Орон нутгийн төсвөөс	132001	215,461,500.00	214,409,892.00	1,051,608.00	99.51	
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>		<b>2,294,400.00</b>	<b>4,089,000.00</b>	<b>(35,000.00)</b>	<b>178.22</b>	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1200041	2,224,400.00	3,984,000.00	(1,759,600.00)	179.10	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1200042	70,000.00	105,000.00	(35,000.00)	150.00	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>345,162,505.78</b>	<b>345,162,505.78</b>	<b>-</b>	<b>100.00</b>	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>345,162,505.78</b>	<b>79,733,043.76</b>	<b>267,189,062.02</b>	<b>23.10</b>	
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>						
БАЙГУУЛЛАГЫН ТОО			1.0	1.0	-	100.00
Төсвийн байгууллага			1.0	1.0	-	100.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО			76.5	75.0	1.5	98.04
Удирдах ажилтан			3.0	3.0	-	100.00
Гүйцэтгэх ажилтан			47.0	46.0	1.0	97.87
Үйлчлэх ажилтан			26.5	26.0	0.5	98.11
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)			685.0	685.0	-	100.00
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД			685.0	685.0	-	100.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа<sup>1</sup> илрээгүй, залруулга хийгээгүй.

Аудитаар залруулаагүй 11,530.9 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч 1,779.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 9,751.6 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага тус тус хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 7 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 11,530.9 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 34,744.8 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

#### 3.1 Төлбөрийн акт

3.1.1. Тушаал шийдвэргүй буюу тушаал шийдвэрээс зөрүүтэй мэдээлэл оруулснаас улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал 1,026.7 мянган төгрөг, алба хаасан хугацааны нэмэгдэл 398.4 мянган төгрөг, нийт 1,425.1 мянган төгрөгийн цалин нэр бүхий 6 ажилтанд илүү олгожээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" мөн "Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 "Төрийн албан хаагч дараахь нийтлэг үүрэг хүлээнэ": 37.1.6 "харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2. Нийгмийн даатгалын улсын байцаагчийн 2025.05.08-ны өдрийн № 27 дугаар бүхий актаар хувь хүнээс суутгах 217.8 мянган төгрөг, алданги 136.3 мянган төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрчээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9 "энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 3.2 Албан шаардлага

3.2.1. Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг олгохдоо зөвхөн "Хувь хүний орлогын албан татвар" 10 хувь 1,997.1 мянган төгрөг суутган 17,974.0 мянган төгрөгийг 69 ажилтанд олгохдоо суутган буюу ногдуулан төлөх 4,590.2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тайлагнаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дугаар зүйлийн 19.1 "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна": 19.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2.2 "Балансын урамшуулал олгох тухай" Архангай аймгийн Боловсролын газрын даргын 2025.09.03-ны өдрийн А/38 дугаар тушаал, тус сургуулийн захирлын 2025.09.15-ны өдрийн Б/49 дүгээр тушаалуудыг үндэслэн "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр нягтлан бодогчид 1,559.0 мянган төгрөгийн, няравт 1,105.0 мянган төгрөг нийт "балансын урамшуулал" 2,664.0 мянган төгрөгийг "улирлын үр дүнгийн урамшуулал"-тай давхардуулан олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.2.3. ХХОАТ-ын тухай хуулийн 23.1-т заасан хөнгөлөлтийг 24 ажилтанд 272.0 төгрөгөөр илүү эдлүүлснээс татварыг мөн дүнгээр дутуу, 35 ажилтанд 551.8 мянган төгрөгөөр дутуу эдлүүлснээс татварыг мөн дүнгээр илүү ногдуулан тайлагнажээ.

Энэ нь Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалын хавсралт "Хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 4.4.1 "Тухайн тайлант жилийн 12 сард бүрэн тухайн байгууллагад харьяалагдаж ажилласан ажилтанд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг мөн хуулийн 27.1-д заасны дагуу жилийн эцэст өссөн дүнгээр тооцож, зөрүүг залруулж тайлагнана", 4.4.2 "Тайлант жилийн 12 сарын турш тухайн байгууллагад харьяалагдаж ажиллаагүй ажилтныг Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг суутгагч өссөн дүнгээр тооцох, зөрүүг залруулах үүрэг хүлээхгүй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалын хавсралт "Хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.2.4 Цалингийн программд даатгуулагчийн төрлийг буруу тохируулснаас нэр бүхий 7 ажилтнаас 1,313.1 мянган төгрөгийг илүү суутгажээ.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйл "Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ" болон нийгмийн даатгалын байгууллагаас тогтоосон тухайн жилд мөрдөх "Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрлийн код, хувь хэмжээ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, холбогдох зааврыг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

3.2.5 Д.Дариймаагийн улирлын гүйцэтгэлийн үнэлгээ 45 хувь байхад 30 хувиар, Г.Нандинцэцэгийн үнэлгээ 60 хувь байхад 50 хувиар тус тус буруу мэдээлэл оруулснаас нийт 360.5 мянган төгрөгийн цалинг дутуу тооцон олгожээ.

Энэ нь Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар

баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" мөн "Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 "Төрийн албан хаагч дараахь нийтлэг үүрэг хүлээнэ": 37.1.6 "харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, Н. Дариймаа, Г.Нандинцэцэг нарт дутуу олгосон 360.5 мянган төгрөгийг нөхөн олгох албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү тооцож олгосон	1	1,425.1	1	1,425.1				
Ур чадварын нэмэгдэл илүү тооцож олгосон	1	354.1	1	354.1				
Нийгмийн даатгал дутуу ногдуулсан	1	4,590.2			1	4,590.2		
Балансын урамшуулал олгосон	1	2,664.0			1	2,664.0		
ХХОАТ буруу тайлагнасан	1	823.8			1	823.8		
Нийгмийн даатгал илүү тайлагнасан	1	1,313.2			1	1,313.2		
Цалин дутуу тооцож олгосон	1	360.5			1	360.5		
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>11,530.9</b>	<b>2</b>	<b>1,779.2</b>	<b>5</b>	<b>9,751.6</b>	<b>-</b>	<b>0.0</b>